



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Сар шинийн баярт зориулсан Үндэсний
Бөхийн барилдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29, 15 дугаар зүйлийн 15.1.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Сүрээр дарагч” хэмээх Гал морь жилийн Сар шинийн баярт зориулсан Үндэсний бөхийн барилдааныг 2026 оны 01 дүгээр 30-ны өдөр зохион байгуулсугай.

2.Бөхийн барилдаан зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 3,000,000 (Гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


3.Үндэсний бөхийн барилдааныг чанар үр дүнтэй зохион байгуулж, санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган үр дүнг тооцож ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 01 сарын 28 -ны өдрийн 119 дугаар
нэгдүгээр захирамжийн хавсралт



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН САР ШИНИЙН БАЯРТ ЗОРИУЛСАН ҮНДЭСНИЙ
БӨХИЙН БАРИЛДААНЫ ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	З давсан бөх	ш	4 ш	100,000	400,000
2	Шөвгөрсөн бөх	ш	2 ш	300,000	600,000
3	Үзүүрлэсэн бөх	ш	1 ш	500,000	500,000
4	Түрүүлсэн бөх	ш	1 ш	1000,000	1000,000
5	Тавгийн идээний боов	ш	25 ш	8,000	200,000
6	Ааруул	Кг	1.5 кг	40,000	60,000
7	Өргөмжлөл	ш	4	60,000	240,000
НИЙТ					3,000,000